

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн
хэрэгжилтийн тухай

2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хууль, Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Албан даалгавар зэрэг 4981 шийдвэрийн 9438 заалт (давхардсан тоогоор)-ын хэрэгжилт 85 хувьтай байна.

Улсын Их Хурлын тогтоол, УИХ-ын Байнгын хороодын тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл зэрэг 1544 шийдвэрийн 3720 заалт /давхардсан тоогоор/-ыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласнаас 2076 заалт биелж, 1219 заалт хэрэгжих шатанд, 51 заалтын хэрэгжилт хангалтгүй, 356 заалтын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна. Хэрэгжилт 85.07 хувьтай байна.

Засгийн газрын 3438 шийдвэрийн 5719 заалт (давхардсан тоогоор)-ыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласны 3020 заалт биелж, 2086 заалт хэрэгжих шатанд, 213 заалт хэрэгжилт хангалтгүй, 374 заалтын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна. Засгийн газрын нийт шийдвэрийн хэрэгжилт 85 хувьтай байна.

Яамд 2021 оны жилийн эцсийн байдлаар 2310 шийдвэрийн 4558 заалтыг хяналтад авч ажилласан нь 81.90 хувийн, агентлагууд 483 шийдвэрийн 777 заалтыг хяналтад авч ажилласан нь 87.59 хувийн биелэлттэй байна.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нар 2189 шийдвэрийн 4104 заалт (давхардсан тоогоор)-ыг хяналтад авч ажилласнаас 2002 заалт нь биелсэн 1750 заалт хэрэгжих шатанд, 44 заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт аймаг, нийслэлийн дүнгээр 83 хувьтай байна.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДСЭН ДҮН

2021 оны жилийн эцсийн байдлаар

Яам, агентлаг, аймаг, нийслэл	Хяналтад авсан		Үүний дотор /заалтын тоогоор/					Биелэлтийн хувь
	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	100%	70%	30%	0%	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	
Яамдын дүн	2309	4557	2622	987	381	201	337	81.90%
Агентлагийн дүн	483	777	472	150	37	19	99	87.59%
Аймаг, нийслэлийн дүн	2189	4104	2002	1566	184	44	294	83.00%
ДҮН	4982	9439	5096	2703	602	264	730	85.02%

